

**ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭМЭГТЭЙ АЛБА
ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ЗАРИМ АСУУДАЛ**

**SOME ISSUES OF SOCIAL SECURITY
OF FEMALE POLICE OFFICERS**

В.Амарсанаа

*ДХИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн
Гэмт явдал, цагдаа, дотоодын цэрэг судлалын төвийн
Эрдэм шинжилгээний ахлах ажилтан-багш,
хууль зүйн доктор, цагдаагийн хошууч*

Т.Баярмаа

ДХИС-ийн магистрант

Товч агуулга: Цагдаагийн алба хаагчийг хууль болон хөдөлмөрийн гэрээнд заагаагүй нөхцөлөөр илүү цагаар ажиллуулсны нэмэгдэл хөлсийг олгох нь бүх цаг үед шийдэгддэггүй, эмзэг асуудал болсоор ирсэн нь үнэн юм. Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлснээр цагдаагийн алба хаагчийн цалин, урамшуулал сард тодорхой хувиар нэмэгдэх боломжтой. Энэ нь цагдаагийн алба хаагчдад илүү цагаар ажиллах эдийн засгийн сонирхлыг бий болгож, үүнтэй уялдан ажлын үр бүтээл, чанар дээшлэн, тэдний ар гэр, ахуй амьдралд жаахан ч гэсэн тус дэм өгөх сайн талтай. Гэвч хууль тогтоомжийн хэрэгжилтгүй, царцанги байдлаас шалтгаалан, алба хаагчид болзошгүй эрсдэлийн үед зарцуулах хадгаламж, гэр бүлийн гишүүдийн болон өөрийн эрүүл мэндэд хэрэглэх тодорхой хэмжээний хуримтлал үүсгэх боломжгүй байх зэрэг эдийн засгаас хамааралтай асуудлууд шилээ даран үүсэх сөрөг талтай болохыг анхааран үзэж, судлахыг зорилоо.

Abstract: It is true that the issue of overtime pay for police officers working under conditions not specified in the law or employment contract has always been a sensitive and unresolved issue. By implementing the relevant provisions of the Labor Law, police officers' salaries and bonuses can be increased by a certain percentage per month. This has the advantage of creating an economic incentive for police officers to work overtime, which in turn will improve their work productivity and quality, and provide some support to their families and livelihoods. However, due to the lack of implementation of the law and the lack of transparency, it is intended to examine and analyze the negative effects of economic issues such as the inability of officers to save money to use in times of potential risk and to create a certain amount of savings for their family members and their own health.

Түлхүүр үгс: Ажлын цаг, илүү цаг, нийгмийн баталгаа, өрхийн амьжиргаа.

Keywords: Working hours, overtime, social security, household livelihood.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 23 дугаар зүйлд “Хүн бүр ямар ч алагчлалгүйгээр адил хэмжээний хөдөлмөрт адил хэмжээний шан хөлс авах эрхтэй. Ажил хөдөлмөр эрхэлж байгаа хэн боловч хувийн болон ам бүлийнхээ ахуй, амьжиргааг хүний зэрэгтэй авч явахад хүрэлцэхүйц бөгөөд зайлшгүй тохиолдолд нийгмийн хангамжийн эх үүсвэрээр нэмэн арвижуулсан, хийсэндээ таарсан, хүртээмжтэй шан хөлс авах эрхтэй” (УИХ, 1948) гэж, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын фактын 7 дугаар зүйлийн (а)-д “Бүх хөдөлмөр эрхлэгчдэд наад зах нь цалин

хөлсийг шударгаар тогтоох, аливаа ялгаваргүйгээр адил үнэлгээтэй хөдөлмөрт тэгш цалин хөлс олгох, чингэхдээ тухайлбал, эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдээс доргүй хөдөлмөрлөх нөхцөлийг бий болгох, тэдний адил хөдөлмөрт нь тэгш цалин хөлс олгох, энэхүү фактын заалтын дагуу хөдөлмөр эрхлэгч, түүний гэр бүлийн гишүүдэд хангалуун амьдрах боломж олгох” (УИХ, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт), (с)-д “Тагцхүү ажилласан хугацаа, мэргэшилд үндэслэн зохих дээд шатны ажилд дэвших адил боломжийг хүн бүрд олгох” (УИХ, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт), (d)-д “Амрах зав чөлөөтэй байх, ажлын цагийг зохистойгоор хязгаарлах, ээлжийн амралтыг цалин хөлстэйгөөр эдлүүлэх, баярын өдөрт цалин хөлс олгохыг хамаарна” (УИХ, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт) гэж тус тус заажээ.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 7.4-дэх зорилтод “Хууль сахиулах салбарын эрх зүйн орчныг сайжруулан, бүтээн байгуулалтыг дэмжих, ажиллах нөхцөлийг сайжруулах, мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бэлтгэн, өрсөлдөх чадварыг хөгжүүлнэ”, 7.4.3-д “Салбарын алба хаагчдын цалин хөлсний нэмэгдлийг тухайн жилийн инфляцын өсөлт, өндөр хөгжилтэй орны ижил төрлийн байгууллагын түвшинд хүргэнэ” (газар, 2019, хууд. 326) гэжээ.

Цагдаагийн алба хаагчийг хууль болон хөдөлмөрийн гэрээнд заагаагүй нөхцөлөөр илүү цагаар ажиллуулсан тохиолдолд олгох цалин хөлс болон тэдгээртэй холбогдох асуудлыг хөндөж үзэхэд маргаантай зүйл нэлээд байдаг. ХТХ-ийн холбогдох заалтыг төрийн байгууллагын аль ч шатанд ягштал баримталж, сайтар зохион байгуулан, үр дүнг тооцож ажилласнаар хөдөлмөрийн харилцааны нийгмийн баталгаа хангагдах боломжтой.


Алба хаагчид чиг үүргээ хэрэгжүүлэхдээ баяр, амралтын өдрүүдэд илүү цагаар ажиллах шаардлага зайлшгүй тулгардаг. Тухайлбал, албан ёсоор тэмдэглэн өнгөрүүлж, бүх нийтээр амардаг баярын өдөр жилд дунджаар 11, амралтын өдөр 7 хоногт 2, сард 8, жилд дунджаар 88 удаа тохиодог. Эдгээр өдрүүдэд ажилласан бол ХТХ-д зааснаар тодорхой хэмжээний урамшуулал олгодог. Тодруулбал, ХТХ-ийн 109 дүгээр зүйлд “Нийтээр амрах баярын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол дундаж цалин хөлсийг 2 дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно” (УИХ, Хөдөлмөрийн тухай хууль, 2021), мөн зүйлд “Илүү цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны тав дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно” (УИХ, Хөдөлмөрийн тухай хууль, 2021), “Долоо хоногийн амралтын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны тав дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно” (УИХ, Хөдөлмөрийн тухай хууль, 2021) гэж тус тус хуульчилсан.

ХТХ-ийн 84 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Долоо хоногийн ердийн ажлын цаг 40-өөс дээшгүй байна” (УИХ, Хөдөлмөрийн тухай хууль, 2021), 2 дахь хэсэгт “Ердийн ажлын өдрийн үргэлжлэл найман цагаас илүүгүй байна” (УИХ, Хөдөлмөрийн тухай хууль, 2021), 4 дэх хэсэгт “Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна” (УИХ, Хөдөлмөрийн тухай хууль, 2021) гэж тус тус заасан.

ХЭҮК-оос 2014 онд Цагдаагийн алба хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилт Монгол Улсын Үндсэн хууль, ХТХ, ЦАТХ болон бусад хууль тогтоомж, олон улсын гэрээ, конвенцын заалтыг хэрхэн биелүүлж байгаад хяналт, шалгалт, судалгааны ажил зохион байгуулжээ. Уг судалгаанд Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Өмнөговь, Дундговь аймаг болон Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэг дэх Цагдаагийн газар, хэлтсийн нийтийн хэв журам хамгаалах болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий алба хаагчдыг хамруулсан байна.

Судалгаанд хамрагдсан нийт алба хаагчдаас “Та өдөрт хэдэн цаг ажилладаг вэ?” гэсэн асуултад 5 хувь нь “Өдөрт 8 цаг хүртэл”, 22 хувь нь “8-10 цаг”, 33 хувь нь “10-12 цаг”, 40 хувь нь “12 цагаас дээш хугацаагаар ажилладаг” гэж хариулжээ (комисс, 2015, хууд. 98). Тэгвэл судалгаанд хамрагдсан нийт алба хаагчдаас “Илүү цагаар болон 7 хоногийн амралтын өдөр ажиллаад нөхөж амраагүй бол 1.5 буюу түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлсэн цалин хөлс авч чадаж байна уу?” гэх асуултад “Тийм” гэж 19 хүн буюу 1 хувь, “Үгүй” гэж 643 хүн буюу 79 хувь, “Мэдэхгүй” гэж 163 хүн буюу 20 хувь нь хариулжээ (комисс, 2015). Уг судалгааны үр дүнд үндэслэж, ХЭҮК-оос “Орон тоо дутмаг учраас цагдаагийн алба хаагчид илүү цагаар ажиллаж байх бөгөөд төсөв хүрэлцээгүйн улмаас илүү цагаар, амралтын болон баярын өдөр ажилласан цалинг олгохгүй байгаа нь хөдөлмөрлөх эрхийг зөрчиж байна” гэсэн дүгнэлт гаргасан байна. Ажлын цагийн норм ХТХ-д зааснаас илүү байгаа нь алба хаагчдын хөдөлмөрлөх эрхийг зөрчжээ. Хэдийгээр илүү цагаар ажиллах зөрчил үеийн үед гарч байгаа боловч энэ талаар дорвитой арга хэмжээ авагдахгүй байна. Одоогоос 10 жилийн өмнө явуулсан судалгаагаар ийм үр дүн гарсан бол 2024 оны байдлаар эдгээр зөрчил, дутагдал арилсан эсэх нь эргэлзээтэй.

Зураг 1. Судалгааны санал асуулгын дүн



Бид цагдаагийн байгууллагад ажиллаж буй 825 эмэгтэй алба хаагчид дунд судалгаа явуулахад дараах үр дүн гарсан юм. Судалгаанд хамрагдсан ЦБЭАХ-дад “7 хоногийн ердийн ажлын цаг 40-өөс илүүгүй байдаг. Тэгвэл та өдөр тутамд хэдэн цагийн үүрэг гүйцэтгэж байна вэ?” гэх асуулт тавихад, 305 (37%) алба хаагч “8-10 цаг”, 209 (25.3%) нь “10-12 цаг”, 111 (13.5%) “12-14 цаг”, 46 (5.6%) нь “14-16 цаг” гэсэн бол 154 (18.7%) алба хаагч “Хуулиар тогтоосон ажлын цагийн дээд

хязгаараас үргэлж хэтрэдэг” хэмээн тус тусын ажлын цагийг мэдүүлсэн. Асуулгад оролцогч 825 эмэгтэй алба хаагчдын зөвхөн 209 нь буюу 25.3 хувь нь л ХТХ-д заасан ажлын цагийг баримталдаг бөгөөд бусад нь үргэлж хэтрүүлэн ажилладаг болох нь харагдаж байна.

ЦБЭАХ-ийн сэтгэгдэл. 0-3 насны хүүхэдтэй байхад амралтын өдрөөр илүү цагаар байнга ажиллуулдаг. Гэр бүлдээ зарцуулах цаг хомс. Амралтын өдрүүдийн аль нэг өдөр заавал ажилладаг...


Зураг 2. Судалгааны санал асуулгын дүн



шаардлага тулгардаггүй” гэжээ. Цагдаагийн алба хаагч, тэр дундаа эмэгтэй алба хаагчид ажлын хэт ачааллаас үүдэлтэй тогтмол илүү цагаар ажиллах нь гэр бүл, үр хүүхдэдээ тавих анхаарал, гэр бүлийн халуун дулаан уур амьсгал, хайр халамжаар дутааж үүнээс үүдэн гэр бүл салалт, хүүхдийн өнчрөл гэх мэтчилэн маш олон сөрөг үр дүнд хүрэх эрсдэлтэй байна. Мөн түүнчлэн дээрх сөрөг хүчин зүйлсээс шалтгаалан стресст орж сэтгэл түгших, сэтгэл гутрах, анхаарал төвлөрөлт буурах, ой тогтоолт муудах зэрэг шинжүүд илэрч, ажлын бүтээмж алдагддаг.

Зураг 3. Судалгааны санал асуулгын дүн

Илүү цагаар ажиллах тохиолдолд илүү цагийн хөлсийг олгодог эсэх



ЦБЭАХ-даас “Танд илүү цагаар ажиллах бодит шаардлага гардаг уу?” гэх асуултад, 303 (36.7%) алба хаагч “Илүү цагаар ажиллаж байж оногдсон ажлаа дуусгадаг” гэсэн бол 380 (46.1%) нь “Илүү цагаар ажиллах явдал өдөр тутам, тогтмол гардаг”, 105 (12.7%) нь ажлын цагт ажлаа дуусгасан боловч удирдлагаас шалтгаангүй ажлын байранд байхыг шаарддаг гэсэн бол зөвхөн 134 (16.2%) нь “Илүү цагаар ажиллах

Судалгаанд оролцогчдоос “Илүү цагаар ажиллах тохиолдолд илүү цагийн хөлс олгодог эсэх?” гэх асуултад, 21 (2.5%) алба хаагч “Тийм”, 19 (2.3%) алба хаагч “Зарим үед” гэж хариулсан бол дийлэнх олонх нь болох 785 (95.2%) алба хаагч “Үгүй” гэжээ. Тэгэхээр ЦБЭАХ-дад илүү цагийн хөлс бараг олгодоггүй болох нь судалгаанаас ажиглагдаж байна. Энэ асуудал зөвхөн эмэгтэй алба хаагчдаар үл хязгаарлагдах бөгөөд нийт алба хаагчдад тулгамдсан асуудал болж байна. Төсвийн хүрэлцээгүй байдлаас болж алба хаагчид илүү цагийн хөлс олгох механизм

ажиллахгүй байгаа нь ХТХ-ийг зөрчиж байна.

Амьжиргааны түвшин сайжрахад нөлөөлөх гол зүйлсийн нэг нь илүү цагийн хөлс авах явдал гэдгийг алба хаагчид дурдаж байна. Сард олгодог цалингийн хэмжээ амьжиргаанд хүрэлцээгүй байдаг учир алба хаагчид олон төрлийн зээлд хамрагдах замаар амьжиргаагаа залгуулах явдал түгээмэл. Мөн орон гэртэй болох, газар худалдан авах, хашаа, байшин, машинтай болох зэргээр анхдагч хэрэгцээг хангахын тулд алба хаагчид зээл түгээмэл авч байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Зураг 4. Судалгааны санал асуулгын дүн



Судалгаанд оролцогчдын 42 (5.1%) нь ямар нэгэн зээлгүй байгаа бол 264 (32%) алба хаагч орон сууцны зээл, 124 (15%) нь автомашины зээл, 610 (73.9%) нь цалингийн зээл, 323 (39.2%) нь хэрэглээний зээл, 136 (16.5%) алба хаагч бусад зээлд тус тус хамрагдсан байна.

ЦБЭАХ-ийн сэтгэгдэл: Ажил ачааллыг тэнцвэржүүлэх шаардлагатай байна. Тухайлсан ажил, чиглэл тус бүрд орон тоог нэмэгдүүлж байж нэг хүнд ногдох ачаалал багасаж, гэр бүл, хүүхдэдээ зарцуулах зав гарна. Би урьдчилан сэргийлэх дээр ажиллахад л хугацаатай бичиг, биелэлт, ногоон бүс гээд л бүгд над дээр төвлөрч байсан. Нэг бол илүү цагийн хөлс олгодог баймаар. Илүү цагаар ажиллах тохиолдол бүрд тухайн хугацаанд тохирох мөнгийг хуульд заасан журмын дагуу тогтмол авснаар алба хаагчдын амьжиргааны түвшин сайжрах боломжтой. Энэ тал дээр цагдаагийн алба хаагчид санал нэгтэй байгаа гэж итгэж байна. Цагдаагийн алба хаагч бид ч бас хүн шүү дээ. Гэр бүл, үр хүүхэд, эрүүл мэндээ бодмоор байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу тасралтгүй явагдах ёстой хэдий ч, ХТХ-д заасан ажлын цагийн хэмжээг хэтрүүлэх замаар энэ зорилтыг хангахын төлөө зүтгэх нь бүдүүлэг хэрэг болно. Үүнийг шат шатандаа анхаарч, шийдвэрлэх цаг нь нэгэнт болсон боловч төрийн түшээдийн зүгээс энэ тал дээр анхаарах бодолгүй байгаа нь олон жилийн турш өөрчлөгдөөгүй нөхцөл байдлаас илхэн харагдаж байна.

Цагдаагийн алба хаагчийн үүргээ биелүүлэх баталгааны талаар олон улсын эрх зүйн баримт бичиг болон Монгол Улсын Үндсэн Хуульд заасан хүний эрхтэй нийцсэн дараах заалтууд хуульчлагджээ. Үүнд, ЦАТХ-ийн 86 дугаар зүйлийн 86.1-д “Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад гэмт халдлагын улмаас амь насаа алдсан тохиолдолд 10 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тухайн алба хаагчийн сарын үндсэн цалингийн дунджаар тооцож түүний гэр бүлд нэг удаа олгоно” (УИХ, Цагдаагийн албаны тухай хууль, 2017), 86 дугаар зүйлийн 86.3.1-д “Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээнээс шалтгаалан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30, 60, 90 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн нөхөн олговор олгоно” (УИХ, Цагдаагийн албаны тухай хууль, 2017), 86.8-д “Цагдаагийн алба хаагчийг жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулж, зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ” (УИХ, Цагдаагийн албаны тухай хууль, 2017) гэжээ. Мөн хуулийн 87 дугаар зүйл (Эдийн засгийн баталгаа)-д “Цагдаагийн алба хаагч ээлжийн амралтаараа өөрийн эсхүл эхнэр, нөхрийн төрсөн нутагт ирэх, очих замын зардлыг тухайн үед мөрдөж байгаа автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож 2 жилд нэг удаа олгоно” (УИХ, Цагдаагийн албаны тухай хууль, 2017), “Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, онц байдлын

үед болон голомтын бүсэд үүрэг гүйцэтгэсэн цагдаагийн алба хаагчид албан томилолтын зардлыг ердийн үеийнхээс гурав дахин нэмэгдүүлж олгоно” (УИХ, Цагдаагийн албаны тухай хууль, 2017); “Цагдаагийн байгууллага, алба хаагчийг өндөржүүлсэн бэлэн байдал зарласан үед болон ажлын бус цагаар, шөнийн ээлжид, хээрийн сургууль, дадлагын үеэр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь хүнсний болон эдийн хангалтаар хангаж, хоолны зардлыг олгоно” (УИХ, Цагдаагийн албаны тухай хууль, 2017) гэсэн зохицуулалтыг тусгажээ. Түүнчлэн мөн хуулийн 90 дүгээр зүйлийн 90.1-д “Цагдаагийн алба хаагчид жил бүр ажлын 15 өдрийн үндсэн амралт олгож, биеэр эдлүүлнэ” (УИХ, Цагдаагийн албаны тухай хууль, 2017); 90.2-т “Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий цагдаагийн алба хаагчид алба хаасан 2 жил тутамд ажлын 3 өдрийн, цагдаагийн бусад алба хаагчид алба хаасан 5 жил тутамд ажлын 3 өдрийн нэмэгдэл амралт олгоно” (УИХ, Цагдаагийн албаны тухай хууль, 2017); 90.3-т “Ажлын зайлшгүй шаардлагаар нэмэгдэл амралтаа биеэр бүрэн эдэлж чадаагүй цагдаагийн алба хаагчид түүний зөвшөөрснөөр хоногт ногдох цалинг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгоно” (УИХ, Цагдаагийн албаны тухай хууль, 2017) гэсэн нь ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй алба хаагчийн эрх ашгийг хамгаалсан заалт болсон.

Тэгвэл эдгээр хуулийн заалтуудын хэрэгжилтийн байдал бодит амьдралд тун хангалтгүй байна. Судалгаанд оролцогчдоос “Алба хаагчдын нийгмийн баталгааг хангах байдал ямар байна вэ?” гэх асуултад 439 (53.2%) алба хаагч “Алба хаагчдын нийгмийн баталгаа хангалтгүй” гэсэн бол зөвхөн 50 (6.1%) нь “Алба хаагчдын нийгмийн баталгаа хангалттай” хэмээн үзжээ. Харин нийт судалгаанд оролцогчдын 336 (40.7%) нь “Алба хаагчдын нийгмийн баталгааг хангах ганц хөшүүрэг нь цалин” хэмээн үзсэн нь нийгмийн баталгааг хангах олон талын үйл ажиллагаа, хөнгөлөлт, урамшууллаас хамгийн чухал нь цалин болохыг харуулж байна.

Зураг 5. Судалгааны санал асуулгын дүн

Цагдаагийн байгууллагаас алба хаагчдын нийгмийн баталгааг хангах байдал ямар байна вэ?




Судлаачид “ХТХ-ийн холбогдох заалтыг хэрэгжүүлснээр цагдаагийн алба хаагчийн цалин, урамшуулал сард тодорхой хувиар нэмэгдэх боломжтой. Энэ нь цагдаагийн алба хаагчдад илүү цагаар ажиллах эдийн засгийн сонирхлыг бий болгож, үүнтэй уялдан ажлын үр бүтээл, чанар дээшлэн, тэдний ар гэр, ахуй амьдралд жаахан ч гэсэн тус дэм өгнө” (ННФ, 2020, хууд. 56) гэсэн байр суурийг илэрхийлснээс гадна “Зах

зээлийн харилцааны өнөөгийн нөхцөлд цалин, ахуй хангамж сайн байх тутам мэдлэг, боловсролтой, чадварлаг боловсон хүчнээр цагдаагийн байгууллагын эгнээ өргөжиж, алба хаагчдын ажлын үр нөлөө, чанар дээшлэхийн зэрэгцээ байгууллагын үйл ажиллагаанд ахиц дэвшил гарах нөхцөл бүрдэнэ” (ННФ, 2020, хуудсд. 56-57) хэмээн үзсэнтэй санал нэг байна. Орчин үед техник, технологийн хөгжил маш хурдацтай явагдаж байгаагийн хэрээр, эдгээрийг өндөр түвшинд ашиглах шаардлага тавигдаж байна. Техникийн хөгжлийг дагаад өөрсдийн мэдлэг, чадварыг дээшлүүлээгүй тохиолдолд гэмт хэрэгтэй тэмцэх ажил үр дүнгүй болж, олон тооны иргэд хохирох эрсдэлтэй бид нүүр тулж байна. Гэмт хэргийн гаралт ихсэхээс гадна нуугдмал байдалд шилжиж, субъектийн механик үйлдлээр үйлдэгдэх явдлаас аажмаар технологийн өндөр түвшинд

бүтээгдсэн техникийн тусламжтай үйлдэгдэх байдал руу шилжиж байгаа нь хууль сахиулагчдаас гадна хууль тогтоогчдын санааг зовоож байна. Энэ нөхцөлд хуучин аргаар, муйхраар зүтгэх нь төдийлөн үр дүнгүй байгааг практик ч харуулж байна. Алба хаагчдыг мэргэшүүлэхээс гадна кибер технологи, хиймэл оюун ухаан, интернэт орчинд өндөр түвшинд ажиллах чадвартай алба хаагчдыг ажиллуулах шаардлага тулгарч байгаа бөгөөд эдгээр мэргэшсэн хүмүүсийг зөвхөн цалин, нийгмийн баталгаагаар тогтоон барина. Гэтэл алба хаагчид одоогийн байдлаар цалингаа өрхийн амьжиргаандаа хүрэлцээтэй байвал сэтгэл тайвшрах түвшинд амьдарч байна. Харамсалтай нь улсаас олгож буй цалин алба хаагчдынхаа өрхийн амьжиргаа буюу наад захын хэрэгцээг бүрэн хангахгүй байна.

Зураг 6. Судалгааны санал асуулгын дүн




Судалгаанд оролцогчдын 50 (6.1%) нь одоогийн цалин өрхийн амьжиргаанд хүрэлцээтэй байгааг илэрхийлсэн бол 208 (25.2%) алба хаагч “Зарим үед хүрэлцээтэй байдаг” гэж, харин дийлэнх 567 (68.7%) алба хаагч “Одоогийн цалин өрхийн амьжиргаанд хүрэлцээгүй” гэжээ. Өрхийн амьжиргаанд хүрэлцээгүй байгаа цалингийн асуудлыг шийдвэрлэж чадахгүй байгаа тохиолдолд чадвартай, мэргэшсэн алба хаагчдыг

цагдаагийн байгууллагад тогтвортой ажиллуулах талаар бодох нь эртэдсэн асуудал болно. Цагдаагийн байгууллагын алба хаагчид ч гэлтгүй, төрийн албаны мөрдөстэй байгууллагуудын алба хаагчдын цалингийн хувь, хэмжээ бага байдаг талаар судалгааны ажлуудад тогтмол дурдсан байдаг. Цалин багатай, тэр нь амьжиргаанд нь хүрэлцээтэй үгүй байдаг алба хаагч өөртөө болон гэр бүлдээ зориулж хуримтлал үүсгэнэ гэдэг тун хүндрэлтэй болох нь ойлгомжтой.

Зураг 7. Судалгааны санал асуулгын дүн

Та цалингаасаа хуримтлал үүсгэдэг үү?



Судалгаанд оролцогчдоос “Та цалингаасаа хуримтлал үүсгэдэг үү?” гэх асуултад судалгаанд оролцогчдын 125 (15.2%) нь “Тийм, хуримтлалтай” гэж хариулсан бол 700 (84.8%) алба хаагч “Тийм боломж байдаггүй. Хэрэглээнд зарцуулаад дуусдаг” гэжээ. Эндээс ЦБЭАХ-дын нийгмийн баталгаа бүрэн утгаараа хангагддаггүй болохыг харж болно. Учир нь ажил хийж, цалин авч байгаа хүн өөрт болон гэр бүлийн гишүүдэд үүсэж болзошгүй эрсдэлийн үед хэрэглэх, зохих хэмжээний мөнгөн дүнгийн хуримтлалтай байж,

эрүүл мэндийн байдал ба осол гэмтэл гэх зэрэг гэнэтийн аюул үүссэн нөхцөлд хэрэглэх замаар амь нас, эрүүл мэндээ хамгаалах шаардлагатай. Гэтэл ЦБЭАХ-дад энэ талын боломж тун тааруу байгаа нь алба хаагчдын нийгмийн баталгаа хангалтгүй байдаг, энэ тал дээр улсаас анхаарахгүй байгаа нь цалин хөлсний хангалтгүй байдал болон илүү цагийн хөлс олгодоггүй зэргээс харагдаж байна.

Цалингаасаа хуримтлал үүсгэх боломжгүйгээс гадна наад захын хэрэгцээгээ бүрэн хангах боломжгүй байгаа алба хаагчид цалингаасаа тодорхой хувийг өөрийн албан хэрэгцээнд ашиглах шаардлага практикт тулгарч байна.

Зураг 8. Судалгааны санал асуулгын дүн



Судалгаанд оролцогчдоос “Та цалингаасаа өөрийн албан хэрэгцээнд ашиглах шаардлага гардаг уу?” гэх асуултад 533 (64.6%) нь “Зарим тохиолдолд”, 98 (11.9%) нь “Үгүй” гэсэн бол 194 (23.5%) алба хаагч “Байнга” гэх хариултыг сонгосон нь анхаарал татаж байна. Энэ байдал нь мэдээж хэрэг цагдаагийн байгууллагын зүгээс олгож байгаа хангалтын дутмаг байдалтай шууд холбоотой. Албанаас олгож байгаа хангалт нь мөн л алба хаагчдын нийгмийн баталгаанд

хамаарах тул жижиг гэлтгүй хангалтын тал дээр илүү анхаарах нь зүйтэй.

Зураг 9. Судалгааны санал асуулгын дүн

Таныг жирэмсэн, эсхүл гурав хүртэлх насны хүүхэдтэй байх үед өөрийн тань зөвшөөрөлгүй шөнийн цагаар ажиллуулж байсан уу?



ЦБЭАХ-дад тавьсан “Таныг жирэмсэн, эсхүл гурав хүртэлх насны хүүхэдтэй байх үед өөрийн тань зөвшөөрөлгүй шөнийн цагаар ажиллуулж байсан уу?” гэх асуултад, 577 (69.9%) алба хаагч “Үгүй” гэсэн бол 248 (30.1%) нь “Тийм, шөнийн цагаар ажиллуулах нь түгээмэл” гэжээ.

Энэ мэтээр ХТХ-д заасан ажлын цагийн стандартаас хэтрүүлэн ажиллуулснаар ЦБЭАХ-дад ажлаас халсрах шинжүүд илрэхээс гадна гэр бүлийн тогтвортой байдал алдагдах хүртэл асуудлыг үүсгэж байна.

Сүүлийн жилүүдэд өөрийн хүсэлтээр албанаасаа гарсан алба хаагчийн тоо эрс өссөн, орон тоо дутагдалтай, ялангуяа алслагдсан газар, орон нутагт ажиллах, эсхүл нарийн мэргэжлийн хүний нөөц бүрэн нөхөгдөж чадахгүй байгаа нь цалин хөлс, төсөв, санхүүжилтээс шалтгаалсан нийгмийн баталгааны хэрэгжилт хангалтгүй байх суурь хүчин зүйл болж байна.

Төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллагын цалин хөлсний хэмжээ хоорондоо харьцангуй зөрүүтэй байгаагаас цалин хөлс багатай байгууллагын алба хаагчид, өндөр цалинтай байгууллага руу шилжих хөдөлгөөн, төрийн албанаас гарч хувийн хэвшлийн байгууллагад, эсхүл гадаад оронд ажиллах шилжилт хөдөлгөөн нэмэгджээ. Энэ шилжилт хөдөлгөөнийг зогсоож, алба хаагчдын нэг ажил, үүргээ тогтвортой, удаан хугацаанд гүйцэтгэх нөхцөлөөр хангах явдал мөн л тулгамдсаар байна.

ЦБЭАХ-даас гадна иргэдийн эрүүл мэндийн байдал бодит амьдралд тулгамдсан асуудал болж байгаа нь сүүлийн үеийн судалгаагаар харагдаж байна. Агаарын бохирдлын хэмжээ огцом нэмэгдсэн талаар сүүлийн үед олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хурцаар шүүмжлэхээс гадна төрийн албан тушаалтнуудын авлигын хэрэг, гүйцэтгэх албан тушаалтнуудын хүнд суртал гэх мэт

маш олон асуудал дийлэнх иргэдийн анхаарал хандуулах сэдэв болж ирснээс түлхүү анхаарал хандуулж байгаа асуудал бол агаарын бохирдол юм. Улаанбаатар хотын агаарын бохирдлын асуудал жил жилийн өвөлдөө хөндөгддөг, хэвшил болсон зүйл юм. Тэгвэл цагдаагийн байгууллагын алба хаагчдын эрүүл мэндийн байдал яг үүнтэй нэгэн адил хэвшил болсон, шийдэгддэггүй асуудалд хамаарах болжээ.

Судалгаанд оролцогчдын 368 (44.6%) нь жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамрагдаж чаддаггүй талаараа үзэл бодлоо илэрхийлсэн байна.

Тэгэхээр ЦБЭАХ-дын нийгмийн баталгаа бодит амьдралд бүрэн хангагдахгүй байгаа талаар судалгаанд оролцсон алба хаагчдын зүгээс илэрхийлсэн явдал нь алба хаагчдаас өдөр тутмын ажлын үр дүн нэхэхийн хажуугаар тэдний нийгмийн баталгааг хангахад анхаарч, дорвитой, үр дүнтэй ажил, арга хэмжээг зохион байгуулахаас гадна хуулийн зарим зүйл, заалтыг алба хаагчдад ээлтэй байдлаар өөрчлөх хэрэгцээг шаардаж байна. Энэ талаар шат шатны удирдлагын зүгээс анхаарч, тусламж шаардлагатай байгаа алба хаагчдад үзүүлэх нийгмийн баталгааг хангах талын дэмжлэг үзүүлэх бодлого баримтлан ажиллах нь цагдаагийн алба тогтвортой ажиллаж, гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэж, нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, захиргаа, хүний нөөц, урьдчилан сэргийлэх болон бусад чиг үүргээ үр ашигтай гүйцэтгэж, ард олны амгалан тайван байдлыг итгэлтэйгээр сахин хамгаалах нөхцөл бүрдэж, “амар тайван амьдралын төлөө хамтдаа” зүтгэх урам зориг хайрлах юм.

Дүгнэлт

1. Цагдаагийн алба хаагч, тэр дундаа эмэгтэй алба хаагчид ажлын хэт ачааллаас үүдэлтэй тогтмол илүү цагаар ажиллах нь гэр бүл, үр хүүхдэдээ тавих анхаарал, гэр бүлийн халуун дулаан уур амьсгал, хайр халамжаар дутааж үүнээс үүдэн гэр бүл салалт, хүүхдийн өнчрөл гэх мэтчилэн маш олон сөрөг үр дүнд хүрэх эрсдэлтэй байгааг судалгааны үр дүн харуулж байна. Уг сөрөг хүчин зүйлсээс шалтгаалан стресст орсноор алба хаагчдын ажлын бүтээмж алдагдаж байна.

2. ЦБЭАХ-дын нийгмийн баталгаа бодит амьдралд бүрэн хангагдахгүй байгаа талаар судалгаанд оролцсон алба хаагчдын зүгээс илэрхийлсэн явдал нь тэдний нийгмийн баталгаа хангагдахад гол нөлөө үзүүлдэг цалин болон илүү цагийн хөлсийг нэмэх шаардлагатай болохыг харуулж байна. Энэ тал дээр дорвитой, үр дүнтэй ажил, арга хэмжээг зохион байгуулахаас гадна хуулийн зарим зүйл, заалтыг алба хаагчдад ээлтэй байдлаар өөрчлөх хэрэгцээтэй. Хэт их ачаалалтай байдал цагдаагийн албаны өдөр тутмын үйл ажиллагаанд тогтмол тохиолддог учир тухайн ачаалалд тохирсон илүү цагийн хөлсийг цаг тухайд нь олгож хэвших байдлыг зарчим болгон ажиллах нь зүйтэй.

Санал

1. Эхний ээлжид өрх толгойлсон эмэгтэй алба хаагчдын судалгааг Цагдаагийн байгууллагын нийт бие бүрэлдэхүүний хэмжээнд бодитой гаргаж, тэдний амьжиргааны түвшинг тогтоосны үндсэн дээр боломжтой бол орон сууц олгох, эсхүл нөөц бололцооноос хамаарч, өрх толгойлсон эмэгтэй алба хаагчдыг орон сууцны 5 хувийн хөнгөлөлттэй зээлд яаралтай хамруулах, нэг бол байраа түрээслээд өмчлөх хэлбэрээр орон сууцжуулах;

2. ЦБЭАХ-д өдрийн 8 цагийн ажлыг гүйцэтгэсэн тохиолдолд ажлын ачаалал болон тухайн гардан гүйцэтгэж байгаа ажил, арга хэмжээ эцэслээгүйг үл харгалзан тухайн өдрийн ажлыг дуусгавар болгохыг цагдаагийн байгууллагын бүх бие бүрэлдэхүүнд хэвшүүлэн ажиллах;

3. ЦБЭАХ хүүхэд асрах чөлөөтэй байх хугацаанд түүний ажлын байрыг хадгалж бусад албан хаагчдад ажлын ачаалал үүсгэх нь ажлын үр дүн болон байгууллагын хэвийн үйл ажиллагаанд тодорхой хэмжээгээр сөрөг нөлөө үзүүлдэг. Иймд ЦБЭАХ-ийн хүүхэд асрах чөлөө авах хүсэлтийг шийдвэрлэхийн зэрэгцээ, эхийг нь эцээхгүй, тугалыг нь тураахгүй байх үүднээс, түүний оронд ажиллах алба хаагчийг түр хугацаанд (хүүхэд асрах чөлөө авсан эмэгтэй алба хаагч ажилдаа буцаж орох хүртэл) шууд томилох;

Ашигласан материал

1. Засгийн газар, М. У. (2019). *Алсын хараа 2050. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого*. Улаанбаатар.

2. Хүний эрхийн үндэсний комисс, Х. э. (2015). *Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэл*. Улаанбаатар.

3. ННФ, Д. (2020). *Цагдаагийн алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлт хүний эрхийн зарчимд нийцэж буй эсэх*. Улаанбаатар.

4. УИХ, У. И. (1948, 12 10). *Хүний эрхийн түгээмэл тунхаглал*. Retrieved 02 10, 2025, from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail/1271>

5. УИХ, У. И. (2017, 02 09). *Цагдаагийн албаны тухай хууль*. Retrieved 02 28, 2025, from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail/12469&menuid=74>

6. УИХ, У. И. (2021, 07 02). *Хөдөлмөрийн тухай хууль*. Retrieved 02 20, 2025, from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230709635751>

7. УИХ, У. И. (n.d.). *Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт*. Retrieved 02 28, 2025, from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail/1284>